



## “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

### Журам батлах тухай


Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 340 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсгийн ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бүртгэлийн хяналтын журам”-ыг 3 дугаар хавсралтаар, “Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам”-ыг 5 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заварчилгаа өгөх журам”-ыг 6 дугаар хавсралтаар, “Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журмуудыг “Таван толгой түлш” ХХК-ийн нийт ажилтан албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага, тэдгээрийн ажилтнууд батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Дээрх журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрхзүй, аудитын алба болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсэгт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.ГАНБААТАР

	ХАБЭА-н Зааварчилгаа өгөх журам	СУАЖ-ХЗӨЖ-009	Хавсралт №6 БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1 Тушаал № <i>А/Б/6</i>	Баталсан огноо: 2019 он /11 сар/ өдөр

## ХАБЭА-Н ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	<i>[Signature]</i>	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	<i>[Signature]</i>	Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэлийн хяналтын ажилтан	

	ХАБЭА-н Зааварчилгаа өгөх журам	СУАЖ-ХЗӨЖ-009	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2019он .... сар .... өдөр
		Тушаал №	

## ХАБЭА-н ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэлийн хяналтын ажилтан	

ХАБЭА-н Зааварчилгаа өгөх журам	СҮАЖ-ХЗЭЖ-009
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

ХАБЭА-н Зааварчилгаа өгөх журам	СҮАЖ-ХЗЭЖ-009
	Хувилбар: 1

### Агуулга

Нэг. Журмын зорилго	4
Хоёр. Зааварчилгаа өгөх:	4
Гурав. Үүрэг хариуцлага:	4

ХАБЭА-н Зааварчилгаа өгөх журам	СҮАЖ-ХЗЭЖ-009
	Хувилбар: 1

### **Нэг. Журмын зорилго**

1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг хийх ажил, батлагдсан сэдэвтэй нь уялдуулах, ИТА, ажилтан нарын оролцоог нэмэгдүүлэх, ажилтанд өгөх үр өгөөжийг дээшлүүлэх стандартад заагдсан шаардлагад нийцүүлэхэд журмын зорилго оршино.

### **Хоёр. ХАБЭА-н Зааварчилгаа өгөх:**

2.1. Гүйцэтгэх ажил, ажлын байрны нөхцөл гэсэн хэсэгт хийгдэх ажлын товч агуулга түүний ямар орчинд гүйцэтгэх, өндөрт ажиллах, ил задгай газар, хязгаарлагдмал орчин, хэт халуун хүйтэн, худаг суваг дотор ил гал хэрэглэх химийн бодисын талаар бичиж анхааруулсан байна.

2.2. Мэргэжлийн зэрэг аюулгүй ажиллагааны групп гэсэн хэсэгт цахилгаан тоноглол засвар үйлчилгээ хийдэг ажилтнуудын аюулгүй ажиллагааны группыг дулаан механикийн тоноглолд засвар үйлчилгээ хийдэг ажилтнуудын мэргэжлийн зэргийг тэмдэглэнэ.

2.3. Зааварчилгаа өгсөн хүний нэр, албан тушаал, гарын үсэг гэсэн баганын дагуу зааварчилгаа өгч байгаа ИТА он сар өдөр цаг минутыг тодорхой бичсэн байна.

2.4. Өдөр тутмын зааварчилгаа нь гүйцэтгэх ажлын заавартай уялдсан, аюулгүй ажиллагааны дүрэм стандартуудын заалтыг тусгасан учирч болзошгүй аюул, түүний эрсдэлийн талаар товч тодорхой бичигдсэн байх ёстой.

2.5. Ээлжит бус давтан зааварчилгааг MNS4969-2000 стандартын 4.15 д заагдсан нөхцөл байдалын үед өгнө.

2.6. Алба, хэлтэс, нэгж бүр ерөнхий инженерийн батлагдсан сэдвийн дагуу сар бүр ээлжит давтан зааварчилгааг өгнө. Батлагдсан сэдвийн хүрээнд зааварчилгааг ИТА нар ээлжлэн боловсруулж ажилтнуудад өгөх ба зааварчилгааны агуулгын хүрээнд ажилтнаас шалгалт авч түүний хүртээмж, чанарыг үнэлж дүгнэсэн байна.

### **Гурав. Үүрэг хариуцлага:**

3.1. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн хэрэглэх ба журмын хэрэгжилтэд ХАБЭА хэсэг хяналт тавина. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан инженерүүд ХАБЭА-н зөвлөлийн гишүүд хяналт тавих ба зөрчсөн ИТА ажилтнууд хөдөлмөрийн болон ХАБЭА тухай холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын хүрээнд хариуцлага тооцно.